

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Б. Гунгаадаш ШУА-ийн
сурвалжлагч гишүүн

«ЗУРАГЗҮЙН ТҮРЭМГИЙЛЭЛ»

Бусад орны юуны өмнө хөрш зэргэлдээ улс орны нутаг дэвсгэрт шунахайран өнгөлзөх, цаашлаад дэлхий дахиныг ноёрхох гэж санаархах явдал өнөөгийн хятадын гадаад бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг болж байна. Эрт дээр үеэс уламжилж XIX зууны эцэс, XX зууны эхээр хятадын үндэсний хөрөнгөтөн цэргийн эрхтнээр дамжин эцсийн бүлэгт маоизмын гол сүнс болон шингэсэн «хятадын төвлөн захирах» үзэл санааг илэрхийлдэг нэг хэлбэр нь «Зурагзүйн түрэмгийлэл» юм. Харин «Зурагзүйн түрэмгийлэл» гэдэг томъёоллын тухайд гэвэл, тэр нь улс төрийн хэллэгийн санд анх хориод оны үеэр гарч ирсэн билээ.

XX зууны хориод оны эхээр Шведийн Рудольф Челлэн: улс бол цаг үргэлж өсөн өргөжөхийг тэмүүлж байдаг газарзүй, биологийн организм юм гэдэг харгис геополитик онолыг гаргажээ. Түүний нь итали, германы фашистууд шүүрэн авч бусдын нутаг дэвсгэрийг булаан эзлэх бодлогоо сурталчлахад өргөн ашиглажээ. Чухам тэр үеэс фашистууд бусад улс орны газар нутгийг өөрсдийн нутаг дэвсгэр болгон үзүүлсэн янз бүрийн газрын зургийг өдий төдийгөөр хэвлэх аргад шилжсэн юм.

Энэ балмад аргыг «зурагзүйн түрэмгийлэл» гэж улс төрийн хэлэнд томъёолох болсон ажээ. Ер нь газрын зураг бол дэлхийн гадрага дээр болж байгаа үзэгдэл, тэдний хэлхээ холбоо, харилцан нөлөөлөх байдал, учир утгыг хүмүүст дүрслэн ойлгуулах хамгийн хямд төсөр арга билээ. Бусдын газар нутгийг эзлэх түрэмгий үзэл санаагаар хүн ард, ялангуяа тэдний өсвөр үеийнхнийг мунхруулан хордуулах фашист аргыг хятадын жанжлах дээрэнгүй үзэлтнүүд зээлдэн авчээ. Тэд улс орноо харийн империалист колоничлогчдын ноёрхлоос чөлөөлөх гэсэн хятадын ард түмний тэмцлийг өөрсдийн зорилгод, тухайлбал, хятадын ноёрхлыг дэлхий дахинд тогтоох зорилгодоо ашиглахын тулд «алдагдсан нутаг» гэсэн нэр томъёо хэрэглэх болжээ. Хятадын засгийн эрхийг 1927 онд булааж авсан Чан Кайшийн цэргийн эрхтний бүлэг бусдын газар нутагт өнгөлзөх бодлогоо газрын зургаар илэрхийлэх аргыг янз бүрийн сурах бичиг, ном зохиолд өргөн хэрэглэж байв.

Гэтэл Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсаны дараа маогийн бүлэг Чан Кайшийнхний дээрхи зальхай аргыг няцаах байтугай үргэлжлүүлэх замд оржээ. 1950 оны 9-р сард Бээжинд хэвлэсэн «Хятадын газрын зураг», 1951 оны 4-р сард Шанхайд хэвлэсэн «БНХАУ-ын мужуудын атласт» хятадтай хөрш зэргэлдээ орших хэд хэдэн орны нутгийн аль нэгэн хэсгийг хятадынх болгож зурсан байв. Тэр үед хятадын «зурагзүйн түрэмгийллийг» хэд хэдэн улс албан ёсоор эсэргүүцэхэд БНХАУ-ын засгийн газар туршлага дутаж, хугацаа давчдсан учир гоминьданы үеийн газрын зургийг сайтар нягтлан шүүлгүй тэр хэвээр нь хэвлүүлэхэд хүрлээ гэдгээр шалтаг зааж уучлал хүлээж байжээ. Гэтэл хэрэг дээр тийм биш, урьдаас төлөвлөсөн алсын зорилготой байсан

нь дээрхи алдаагаа 1953 онд «БНХАУ-ын мужуудын атлас», 1954 онд «Дэлхийн шинэ атлас», 1957 онд «БНХАУ-ын атлас» гэхчилэн олон төрлийн газрын зураг, атлас хэвлэхдээ давтан үргэлжлүүлснээр илэрч байв. Ийнхүү «зурагзүйн түрэмгийллийг» БНХАУ-ын маоист удирдлага гадаад бодлогынхоо чухал нэг зэвсэг болгон хэрэглэж эхэлсэн билээ. Тэгэхдээ бас гоминданыхны зохиосон «алдагдсан нутаг» гэгчийн зэрэгцээгээр «тогтоогдоогүй хил» гэдэг шинэ томъёог гаргаж ирсэн байна. Үүнийг 1956 онд Шанхайд хэвлэсэн «Хятадын мужуудын атлас», Бээжинд хэвлэсэн «Хятадын атлас», 1972 онд Бээжинд хэвлэсэн «Дэлхийн атлас», 1974 онд Бээжинд хэвлэсэн «БНХАУ-ын мужуудын атлас» болон дараа дараачийн олон зурагт «тогтоогдоогүй хил» гэсэн таних тэмдгийг өргөн хэрэглэсэн явдал нотлож байв.

Бээжингийн маоист удирдлага «зурагзүйн түрэмгийлэлдээ» зөвхөн өөрсдийн зураг, атласаар зогсохгүй бусад орны хэвлэлийг ч урвуулан ашиглах болжээ. Нэгэн жишээг дурдахад 1954 онд дунд сургуулийн VII, VIII ангид зориулж Москвад хэвлэсэн ЗХУ-ын газарзүйн атласыг хятад хэлэнд орчуулж Бээжинд хэвлэхдээ түүний 39, 41, 42-р хуудсанд зөвлөлтийн Баруун, Зүүн Сибиртэй залгаа орших БНМАУ-ын хилийг эх зургаас нь өөрчлөн зурж хэвлэсэн байв. Атласын эцэст хятадын газрын зургийн хэвлэлийн газраас хавсарган нийтлүүлсэн тайлбар өгүүлэлд: «Энэ атласыг ЗХУ-ын газарзүйг сонирхогч өргөн олны лавлах бичиг болгож хэвлэв» гээд «...гэвч туршлага мөхөсдөснөөс энэ атласыг зохих түвшинд хүргэж чадаагүй байж болох учраас дараачийн хэвлэлд засамжлахад зориулж манай редакцид саналаа ирүүлэхийг уншигч олноос хүснэ» гэж бичжээ. Гэтэл энэ атласаас хойш хятадын хэвлэл олон тооны зураг, атлас хэвлэн гаргасны дотор нөгөө л «туршлага мөхөсдөснөөс» болж хөрш зэргэлдээ орны газар нутгийн аль нэг хэсгийг буюу бүхэл бүтнээр нь хятадынх болгон зурах явдал үргэлжлэсээр байв. Энэ нь БНМАУ-ын тухай зураг дээр бүр ч тодорхой харагдаж байна. 1974, 78 онд Бээжинд хэвлэсэн хятадын мужуудын болон бусад зурагт тухайлбал «Диту чубаньшэ» хэвлэлийн газраас эрхлэн нийтлүүлсэн газрын шинэ зурагт БНМАУ-ын нутаг дэвсгэрийг хятадын нутаг дэвсгэртэй ижил өнгөөр тамдэглэжээ. Үүнийг «туршлагагүйгээс» болсон алдаа гэж үзэх үндэс огтхон ч алга. Бээжингийнхэн газрын зураг дээр хөрш орнуудын асар их нутаг, БНХАУ-ын нутаг дэвсгэрээс нэг дахин их хэмжээний нутгийг хятадын нутагтай яг ижил өнгөөр зурж үзүүлсэн юм гэж Ин- донезийн «Мингу мердека» сонинд бичжээ.

Хятадын эрх баригчид жанжлах түрэмгий санаархалдаа хилийн асуудлыг яаж ашигладгийг доорхи баримт бүр ч тодорхой харуулж байна. 1981 оны 8-р сарын 9-нд Бээжингийн радиогийн монгол хэл дээр нэвтрүүлсэн «Маогийн бодлогыг баримталж хилийн асуудлыг шийдвэрлэе» гэсэн өгүүлэлд «Хятад Энэтхэгийн хоорондох 1700 гаруй км хилийн асуудал, ЗХУ, БНХАУ-ын хоорондох 7000 км хилийн асуудал одоо болтол шийдвэрлэгдээгүй байгаагаар барахгүй Зөвлөлт Холбоот Улс хилийн ойролцоо цэрэг бөөгнөрүүлж, хилийн будлиан үүсгэн хятадын нутгийг эзэлсээр байна» гэх мэтээр бодит байдлыг мушгин гуйвуулж байв. «Зурагзүйн түрэмгийлэл» нь яваандаа цэргийн түрэмгийлэл болж хувирдгийг социалист Вьетнамын эсрэг түрэмгийлэл бүр ч хурцаар харуулсан билээ.

Хятадын удирдлагаас хөрш зэргэлдээ орны эсрэг явуулж байгаа «зурагзүйн түрэмгийллийн» өөр нэг хэлбэр нь хэвлэн нийтлүүлж байгаа зураг, атласын тайлбар өгүүлэлд түүхийн үнэнийг мушгин гуйвуулж байгаа явдал юм. Сүүлийн үед «Диту Чубаньшэ» хэвлэлийн газраас олон удаа хэвлэн гаргасан «Дэлхийн атласын» тайлбарт монголын ард түмний

олон зуун жилийн үндэсний эрх чөлөөний тэмцлийг илт үгүйсгэх хандлага гаргаж 1911 онд монгол орон Манжийн ноёрхолыг түлхэж унагасныг монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийн үр дүн биш, харин «Хаант орос улсын турхиралт» мэтээр бичээд империализм, феодализмыг эсэргүүцсэн монголын ард түмний 1921 оны ардын хувьсгалын түүхэн ялалтын тухай юу ч дурдалгүй өнгөрчээ. Түүгээр үл барам хувьсгалын жилд манай орны амьдралд гарсан асар их өөрчлөлтийн тухай юу ч дурдалгүй, харин малын тоо толгой нь цаг ямагт буурч, орчин үеийн аж үйлдвэр бараг хөгжөөгүй мэтээр бичжээ.

Атласын лавламж зохиогчид монгол-зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааны мөн чанарыг гүжирдэн гүтгэх оролдлогоо шургуулалгүй өнгөрч чадсангүй. Ийм учраас хятадын их гүрний жанжлагчдын «зурагзүйн түрэмгийллийг» цаг тухай бүр илчлэн няцааж байх явдал дорнодахины марксист судлалын чухал нэг зорилт мөн хэвээр байна. Энэ нь империалист түрэмгий хүчин дэлхийн зургийг өөрчлөх балмад бодлого явуулж, олон улсын байдлыг ноцтойгоор хурцатгаж буй одоо үед бүр ч чухал юм.

КАРТОГРАФИЧЕСКАЯ АГРЕССИЯ

Резюме

Неотъемлимой частью внешней политики КНР является ее территориальные притязания к соседним странам, что нашло яркое выражение в «картографической агрессии».

Термин «картографическая агрессия» появился в политическом лексиконе в 20-х годах нашего столетия, после возникновения реакционной теории геополитики, которую широко использовали фашисты Германии и Италии для обоснования своих территориальных притязаний.

Китайские гегемонисты взяли на вооружение этот фашистский метод обрабатывания народных масс в духе шовинизма и экспансионизма.

С начала 50-х годов в Китае выходят в свет 2 атласа КНР, на которых некоторые, прилегающие к Китаю районы соседних стран, были отмечены как территория КНР. Оправдываясь отсутствием опыта в составлении карт, правительство КНР вынуждено было принести официальные извинения за переиздание точной копии карт, составленных националистами Гоминьдана. Однако последовавшие за этим «Атлас районов КНР», «Новый атлас мира», «Атлас КНР» были изданы без поправок. Поправки были сделаны лишь в терминологии. Термин «Утраченные территории» был заменен на «неустановленная граница».

В своих притязаниях китайские гегемонисты не останавливаются и перед намеренным искажением географических карт, выпущенных в других странах и переизданных в Китае. Так было с географическим атласом, изданным в 1954 году в Москве для средней школы. В китайском издании атласа была неправильно отражена граница МНР с Западной и Восточной Сибирью.

Неотъемлимой частью «картографической агрессии» является фальсификация истории соседних стран, которая описывается в приложении к географическим атласам.

Агрессия Китая против социалистического Вьетнама наглядно показала, что «картографическая агрессия» легко может перейти в агрессию вооруженную. Поэтому свое временное обличение «картографической агрессии» китайских гегемонистов, по-прежнему, остается одной из важных задач современного китаеведения.